



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 02 өдөр

Дугаар A/01

Батширээт сум

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.5, 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалтууд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/713 дугаар захирамжийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Сумын хэмжээнд агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийн ажлыг холбогдох журамд заасан хугацаанд зохион байгуулж ажиллах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Д. Бүдханд - Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга: А.Эрдэнэчимэг - Батширээт харуулын цаг уурын техникч

Гишүүд:

Б.Бадамгарав - Норовлин багийн Засаг дарга

Э.Цацрал - Татварын улсын байцаагч


Б.Мөнх-Очир - Байгаль орчны хяналтын улсын байцаагч

Б.Сансармаа - Байгаль хамгаалагч

2. Сумын хэмжээнд агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийн ажлыг 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 01 дүгээр сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд холбогдох журмын дагуу зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Бүдханд), тооллогын дүн мэдээг нэгтгэн холбогдох газарт хүргүүлэн ажиллахыг нарийн бичгийн дарга (А.Эрдэнэчимэг) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

БАЛТАНГЭРЭЛ



**232601001**